



НЛМ НОРВЕГИЙН ТУСЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГА, ЗАХИРГААНЫ 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Олон нийтийн харилцаа:

НЛМ Норвегийн тусламжийн байгууллага нь тухайн тайлант жилийн хугацаанд хамтрагч байгууллагуудын олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс бүхий л зөвлөлдөх уулзалт, хурал, форумд идэвхтэй оролцож, үйл ажиллагааг дэмжин ажиллалаа. Үүнд:

- Монгол дахь Олон улсын Төрийн бус байгууллагуудаас зохион байгуулдаг улирал тутмын MINGO уулзалтууд,
- Боловсрол болон эрүүл мэндийн салбарууд, түүнчлэн хүүхдийн эрх, хамгааллын асуудлуудыг эрхэлсэн байгууллагуудтай салбар дундын болон хэсэгчилсэн уулзалт, зөвлөгөөнүүд,
- Байгууллагаас 2003-2008 онд хэрэгжүүлсэн Ноосны Өрхийн Үйлдвэрлэл Маркетинг төслийн үр дүнд бий болсон Ноосон Зангилаа Дундын хоршооны 15 жилийн ойн баяр боллоо. Мөн тус байгууллагын жилийн эцсийн Удирдах зөвлөлийн хуралд Улаанбаатар салбарын захиргааны захирал урилгаар оролцож, 2018 оны 1 дүгээр сард дуусгавар болох тус байгууллагад Тусгай зориулалттай хийсэн үл хөдлөх хөрөнгө бэлэглэлийн гэрээний тухай ярилцлаа. Энэхүү 5 жилийн гэрээг 2013 оны 1 дүгээр сарын 30-ний өдөр 2 байгууллага хамтран байгуулсан бөгөөд гэрээ дуусгавар болох үед Ноосон зангилаа Дундын хоршоо нь Цагаан алт дэлгүүрийг өөрийн нэр дээр албан ёсоор ашиглах эрхтэй болно.

Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас НЛМ Норвегийн тусламжийн байгууллагын үйл ажиллагааны зөвшөөрлийг 2017 оны 6 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл 1 жилийн хугацаатайгаар олгосон байна.

2016 онд хийгдсэн гэрээ хэлэлцээрүүд

- 2016 оны эхэнд “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК нь 2015 оны санхүүгийн жилийн үйл ажиллагаанд хараат бус аудит хийлээ. Түүнчлэн тус байгууллага манай байгууллагын 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд урьдчилсан аудитыг 2016 оны 11 дүгээр сард хийсэн бөгөөд 2016 оны санхүүгийн жилийн аудитыг 2017 оны 1 сард хийж гүйцэтгэлээ. Ийнхүү “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК болон Монгол дахь НЛМ Норвегийн тусламжийн байгууллагын хооронд байгуулсан санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ тухайн тайлант жилээр дуусгавар болж буй бөгөөд НЛМ Норвегийн тусламжийн байгууллага нь Монгол улсын Аудитын хуулийн дагуу шинээр аудитын үйлчилгээ үзүүлэх байгууллагатай ажиллах ёстой. Бид аудитын тайланг төсөл тус бүрээр хавсаргасан болно
- 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдөр НЛМ Норвегийн тусламжийн байгууллага болон Билиг ХХК –ийн хооронд байгуулсан Оффис түрээсийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Монгол дахь Норвегийн тусламжийн байгууллагын ажилтнууд

2016 оны жилийн эцсийн байдлаар Бид 2018 оноос Монгол орны баруун бүсийн аймгуудын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг чадавхжуулах, нийгмийн үйлчилгээ хүртэх боломжийг нэмэгдүүлэх боломжийг бий болгох зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах, нийгмийн орчинг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Одоо НЛМ Норвегийн тусламжийн байгууллагын хэмжээнд Улаанбаатар, Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий салбарт монгол ажилтан 49, гадаад ажилтан 8, нийт 57 хүн ажиллаж байна.

Захиргаа, хүний нөөцийн асуудлууд

- Баян-Өлгий аймаг дахь НЛМ Норвегийн тусламжийн байгууллагын салбар байгуулагдан 2016 оноос бүрэн хүчин чадлаар ажиллаж байгаа бөгөөд оффисын байр болон гадаад ажилтнуудын амьдрах байрыг түрээслэсэн. Салбарын нягтлан бодогч болон жолоочийг 2016 оны 4 дүгээр сараас тус тус шинээр авч ажиллуулж байна.
- Улаанбаатар болон Ховд салбаруудад Онцгой байдлын үед арга хэмжээ авах агуулахыг шинэчилж, Баян-Өлгий салбарт тус агуулахыг шинээр бий болгон тохижууллаа.
- Байгууллагын шинээр захиалсан Toyota Land Cruiser 76 /74-62 УБЦ/ тээврийн хэрэгсэл Диллер компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр захиалгат хугацаанд ирэхгүй хойшилсоор 2016 оны 3 дугаар сард Баян-Өлгийн салбарт хүлээлгэн өгсөн.
- Улаанбаатар салбарын хэрэгцээнд ашиглаж байсан Toyota Prado 95 болон Hyundai Starex тээврийн хэрэгслүүдийг дуудлага худалдаагаар худалдсан бөгөөд Хүүхдийн Эрх Хөгжил 2 төсөлд ашиглаж байсан Форд /02-59 УНЛ/ тээврийн хэрэгслийг Улаанбаатар салбарын хэрэгцээнд худалдан авав.
- Улаанбаатарт гадаад ажилтнуудын түрээслэн амьдарч байсан орон сууцнуудын гэрээ дууссантай холбогдуулан Жаргалан хотхоны ойролцоо Оддын хотхонд дулаан гарааж түрээслэх гэрээ байгуулав.
- 2016 оны 5 дугаар сараас шинээр томилогдсон Санхүүгийн албаны дарга Ховд салбарт ажиллаж эхэлсэн бөгөөд ажлаа хүлээлгэн өгсөн өмнөх Санхүүгийн албаны дарга 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдөр хүртэл санхүүгийн зөвлөхөөр ажиллав.
- Улаанбаатар салбарын менежер 2016 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс Улаанбаатар салбарын захиргаа хариуцсан Захирлаар томилогдон ажиллаж байна.
- 2016 онд бид дараах бодлогын бичиг баримтуудыг шинэчлэн, боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:
 - НЛМ Норвегийн тусламжийн байгууллагын Санхүүгийн бодлого, журам
 - НЛМ Норвегийн тусламжийн байгууллагын Хүний нөөцийн бодлого
 - НЛМ Норвегийн тусламжийн байгууллагын Тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаан бодлого, журам
 - НЛМ Норвегийн тусламжийн байгууллагаас мөрдөх бүх тариф
- НЛМ Норвеги байгууллагаас 2016 оны 11 дүгээр сард НЛМ Монгол байгууллагын 2017 оны төсөвт таналт хийсэн боловч ажилтнуудынхаа цалинг 2 хувь хүртэл нэмэгдүүлсэн.
- Завсар үйлчилгээ:
 - Улаанбаатар дахь байгууллагын өмчлөлийн орон сууцанд 2016 оны зун засварын ажил хийгдэв.
 - Ховд аймаг дахь гадаад ажилтнуудын байранд халаалтын иж бүрэн завсар үйлчилгээ хийгдсэн.

- Ховд аймаг дах байгууллагын төв байрны 2 дугаар давхарын халаалт болон, Норвеги сургуулийн байрны ус алдалт зэргийг сангийн завсар үйлчилгээ хийж завсарлав.
- Улаанбаатар салбарт бүтцийн өөрчлөлт орсонтой холбогдуулан тус салбарт цаашид хэрэглэгдэхгүй болсон оффисын зарим тавилга хэрэгсэлийг Ховд болон Баян-Өлгий салбаруудад шилжүүлэв.

Байгууллагын зүгээс ажилтнуудын мэдлэг мэргэшил дээшлүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Бүх ажилтнуудын сургалт, уулзалт:

- Бүсийн арга хэмжээг Улаанбаатарт 2016 оны 4 дүгээр сард, Баян-Өлгий аймагт 2016 оны 8 дугаар сард тус тус зохион байгуулсан.

Гадаад ажилтнуудын сургалт, уулзалт

- 2016 оны 10 дугаар сард гадаад ажилтнуудын сургалт, уулзалтыг Ховд аймагт зохион байгуулсан бөгөөд шинээр томилогдсон НЛМ Норвеги төв байгууллагын Монголыг хариуцсан бүсийн захирал Ханс Арне Санна үйл ажиллагаанд оролцлоо.

Байгууллагын гадаад ажилтнуудын шилжилт хөдөлгөөн 2016 онд

- Бертил болон Гүнн Андерсон нар 3 хүүхдийн хамт 6 сард гэрээний хугацаа дуусаад Норвеги руу нутаг буцсан.
- Франк Улав болон Черсти нар 3 хүүхдийн хамт 6 сард гэрээний хугацаа дуусаад Норвеги руу нутаг буцсан.
- Арне болон Марианне Торбиорнсен нар 6 сард гэрээний хугацаа дуусаад нутаг буцсан.
- Давид Олсон 2016 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Суурин төлөөлөгчөөр ажилласан. Тэрээр 2016 оны 9 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сард гэрээний хугацаа дуустал шинээр томилогдсон Суурин төлөөлөгчийн зөвлөхөөр ажиллаж байгаал АНУ руу нутаг буцсан.
- Биорн Олав Сорхус нь 2016 оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх 2 төслийн зөвлөхөөр ажиллаж байсан бөгөөд 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс Суурин төлөөлөгчөөр томилогдон ажиллаж байна.
- Яан Ингве Бернсен 2016 оны 6 дугаар сар хүртэл сайн дурын ажилтнаар ажилласан бөгөөд 2016 оны 8 дугаар сараас Баян-Өлгий салбарын захирлаар томилогдон ажиллаж байна.
- Клаудиа Осорио 2016 оны 6 дугаар сар хүртэл Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх 2 төсөлд зөвлөхөөр 50 хувь, Захиргаанд зөвлөхөөр 20 хувь ажиллахын зэрэгцээ Норвеги сургуулийн бусад ажлыг хавсран гүйцэтгэж байв. Тэрээр 2016 оны 9 дүгээр сараас Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх 2 төсөлд зөвлөхөөр 70 хувь, Захиргаанд зөвлөхөөр 10 хувь ажиллаж байна.
- Педер Емил Вигдал Ховд аймаг дах Норвеги сургуулийн захирлаар 2016 оны 8 дугаар сараас эхлэн ажиллаж байна.
- Мирриам Олен 2016 оны 9 сараас Ховд аймаг дах Норвеги сургуулийн туслах багшийн зэрэгцээ, сайн дурын ажилтнаар ажиллаж байна.
- Карен Колбан Хоел НЛМ Монгол дах Норвегийн тусламжийн байгууллагад ажиллах гэрээг 2018 оны 12 дугаар сар хүртэл сунгалаа.
- 2016 оны хавар Улаанбаатар дах Олон улсын сургуульд Норвегийн 3 хүүхэд суралцсан.

- 2016 оны хавар Ховд дахь Норвеги сургуульд 6 Норвеги хүүхэд хамрагдаж байсан бол, мөн оны намар тус сургуульд 3 Норвеги хүүхэд суралцаж байлаа.